



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Огноо: Даваа гараг, 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр

Хаана: Шангри-Ла зочид буудлын хүлээн авалтын их танхим

Хувьцаа эзэмшигчид:	
Голомт Файнэншл Групп ХХК	
Свисс-МО Инвестмент АЖ	
Голомт Инвестмэнд Лимитэд	
Бодь Интернэйшнл ХХК	
Бусад	
Хурлын ирц: 88.48 хувь	
Хувьцаа эзэмшигчдийн хуралд мэдээлэл танилцуулахаар хуралд оролцогчид:	
Гүйцэтгэх захирал	Норихико Като
ТУЗ-ийн гишүүн	Д.Мөнхтөр
ТУЗ-ийн гишүүн	Ж.Үнэнбат
Кэй Пи Эм Жи Аудит ХХК-ийн Ерөнхий захирал	Г.Соёлмаа
Гүйцэтгэх захиралын орлогч	А.Одонбаатар
Ерөнхийлөгч	Г.Ганболд
ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга	З.Солонго
Тооллогын комиссын Дарга-Хуулийн хэлтсийн захирал	Б.Ганбат
Тооллогын комисс:	
Хуулийн хэлтсийн захирал	Б.Ганбат (Дарга)
Удирдлагын мэдээллийн хэлтсийн захирал	Ц.Мөнхтуяа (Гишүүн)
Үйлдвэр худалдааны хэлтсийн захирал	Б.Золбоо (Гишүүн)
Стратеги хамтын ажиллагааны хэлтсийн захирал	Э.Анхбаяр (Гишүүн)
Хуулийн хэлтсийн хуульч	Т.Хүүбаяр (Гишүүн)
ТУЗ-ийн ажлын алба, Хөрөнгө оруулалтын менежер	Э.Тэлмэн (Нарийн бичиг)
Хурал 09:30 цагт эхлэв.	
Голомт Банк ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр Шангри-Ла зочид буудлын хүлээн авалтын танхимд болон www.investor.golomtbank.com веб хуудсаар шууд дамжуулж, танхим цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулагдав. Хуралд Голомт Банк ХК-ийн ТУЗ-ийн гишүүд болон Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд оролцов. Хурлыг Голомт банкны Ерөнхийлөгч Г.Ганболд даргалж, 09 цаг 30 минутад албан ёсоор нээв.	
Хурлын дарга Г.Ганболд: Бид өнөөдөр Голомт Банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулахаар та бүхнийг урьсан. Энэхүү ээлжит хуралд хүрэлцэн ирсэн манай эрхэм хүндэт хувьцаа эзэмшигч та бүхэнд талархлаа илэрхийлье. Өнгөрсөн оны санхүүгийн жилийн үр дүн гарч, хөндлөнгийн аудитаар баталгаажсан ба компанийн тухай хууль болоод нээлттэй хувьцаат компанийн дүрэмд зааснаар бид ээлжит хурлаа 4 сарын 30-аас өмнө хийх ёстой. Энэ өдрүүдэд бүх нээлттэй компаниуд 30-ны өдрөөс өмнө ээлжит хурлаа хийж, 2023 оны ажлынхаа үр дүнг хэлэлцээд хуульд заасан бусад асуудлыг хэлэлцэж байгаа. Голомт банкны хувьд мөн адил өөрийн дүрэм болоод хуульд заасны дагуу ТУЗ-өөс хуралд бэлтгэх тогтоол шийдвэрүүд гарсан. Өнөөдрийн хуралд оролцож байгаа манай хүндэт хувьцаа эзэмшигчдэд өнөөдрийн хурлаар хэлэлцэх материалтай танилцаж ирсэн байх гэж бодож байна.	
Өнөөдрийн хурлаар бид нийт 7 асуудал хэлэлцэхээр төлөвлөсөн. ХЭХ-ын Тооллогын комисс нийт 6 хүний бүрэлдэхүүнтэй, Голомт банкны Хуулийн хэлтсийн Б.Ганбат захирлаар ахлуулсан баг байна. Гишүүдээр Санхүү удирдлагын газрын хэлтсийн захирал Ц.Мөнхтуяа, Байгууллагын банкны газрын хэлтсийн захирал Б.Золбоо, Мэдээлэл технологийн газрын хэлтсийн захирал Э.Анхбаяр, Хуулийн хэлтсийн хуульч Т.Хүүбаяр, мөн ТУЗ-ийн ажлын албаны менежер Э.Тэлмэн ажиллах болно. Тооллогын комисс эхний ээлжинд хурлын ирцийг хуульд нийцсэн эсэх, ирц бүрдсэн эсэхээр бидэнд мэдээлэл өгөх ёстой. Өнөөдрийн хурлыг мөн хурлын цахим хуудаснаа шууд дамжуулж, хувьцаа эзэмшигчдэд хурлын үйл ажиллагааг онлайнаар давхар хүргэж байгаа. Онлайнаар дамжуулж байгаа хуралд хэдэн хувьцаа эзэмшигч оролцож байна хэр их хүн саналаа өгөх бололцоотой байна гэдгийг бүртгээд хянах боломжтой байгаа.	



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Огноо: Даваа гараг, 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр

Хаана: Шангри-Ла зочид буудлын хүлээн авалтын их танхим

Танхимд болоод арын албанд манай техникийн баг ажиллаж байна. Энэ танхим 80 орчим хувийн дүүргэлттэй, хурлын зарын дагуу биечлэн ирж хуралд оролцох хүсэлтээ өгсөн манай хувьцаа эзэмшигчид цугласан байна. Ингээд хурлыг албан ёсоор нээснийг мэдэгдээд ТУЗ-ийн тогтоолын дагуу миний бие энэ хурлыг Голомт банкны ерөнхийлөгч Ганболд миний бие даргалан явуулна. Мөн тус банкны Гүйцэтгэх захирал Ноён Норихико Като захиралтай хамтарч бид хоёр хурлыг удирдах болоод хурлын ажиллагааг зохион байгуулахад оролцож ажиллана.

Өнөөдрийн хурлыг тодорхой дэгийн үндсэн дээр хуульд болон дүрэмд заасны дагуу зохион байгуулна. Хурал 09:00 цагт эхэлж үд үеэр өндөрлөх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Хурлын дэгийг танилцуулав:

- Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэрт заасан эрх бүхий албан тушаалтан хурлыг удирдан явуулна.
- Хурлын ирцийг Тооллогын комисс танилцуулснаар Хурлын дарга албан ёсоор хурлыг нээнэ.
- Компанийн тухай хуульд заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалд тусгагдаагүй асуудлыг хэлэлцэхгүй.
- Хувьцаа эзэмшигчдийн хурлыг тогтоосон цагийн хуваарийн дагуу явуулна.
- Хувьцаа эзэмшигчдийн хурлыг мэргэжлийн хөндлөнгийн компаниар бичлэг хийлгэж цахим хэлбэрээр шууд дамжуулалт хийх ба энэхүү бичлэг баримт болон компани дээр хадгалагдана. Өөр ямар нэгэн хэлбэрээр дуу, дүрс бичлэг хийхгүй.
- Хувьцаа эзэмшигч хурлыг аливаа хэлбэрээр үймүүлэх, зориуд саатуулах, бүдүүлэг үг хэллэг ашиглан бусдыг доромжлох, бусдын нэр төрийг гутаах, гүтгэхийг хориглоно.
- Хурлын дэгийг зөрчсөн хувьцаа эзэмшигчид эхний удаа Хурлын дарга урьдчилан сануулна. Зөрчлийг дахин гаргасан хувьцаа эзэмшигчийг Хурлын даргын зөвшөөрлөөр Зохион байгуулах комисс хурлаас гаргах арга хэмжээг авна.
- Хурлаар хэлэлцэх асуудлуудыг хэлэлцэж дууссаны дараа санал хураалт явуулж, Тооллогын комисс хэлэлцсэн асуудал тус бүрээр хувьцаа эзэмшигчдийн өгсөн саналыг нэгтгэж, Тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулна. Та бүхэн харж байна зааланд манай улаан дүрэмт хувцастай ажилчид байна бүгд таблеттэй зогсож байгаа. Таны гар утас санал хураалтад оролцоход ямар нэгэн бэрхшээл гарвал манай зохион байгуулагч нарт хандаарай.
- Хурлын дарга Тооллогын комиссын тогтоолд үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан шийдвэрийг танилцуулж, хурал хаасныг мэдэгдэнэ.

Хурлын дэг компанийн тухай хууль болоод Санхүүгийн Зохицуулах Хорооноос гаргасан тогтоол, манай компанийн журамд бүрэн нийцэж байгаа. Хурлаар хэлэлцэх асуудал бүр дээр хэрхэн санал өгөх талаар манай тооллогын комиссын дарга та бүхэнд дэлгэрэнгүй танилцуулна. Санал өгөх процесс нь манай хурлын чухал хэсэг шийдвэр гаргах процесс байгаа. Тооллогын комиссын дарга Б.Ганбат захирлыг өнөөдрийн хурлын ирцийг танилцуулахыг урьж байна.

Тооллогын комиссын дарга Б.Ганбат: Нийт хувьцаа эзэмшигч та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. 2024 оны 4 сарын 15-ны өдрийн 09:00 цагаар тасалбар болгон тооллогын комиссын тогтоолыг танилцуулъя. Компанийн тухай хуулийн 67-р зүйлийн 67.3.1, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Голомт банкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гарах бүртгэлийн өдрөөр нийт энгийн 808,657,306 ширхэг хувьцаанаас 715,514,208 ширхэг хувьцаа буюу нийт хувьцааны 88.48 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд бүртгүүлсэн. Үүнд зайнаас холбогдсон, биечлэн ирсэн байх тул хурлыг хүчин төгөлдөрт тооцугай. Тооллогын комиссын дарга Б.Ганбат, гишүүд Ц.Мөнхтуяа, Б.Золбоо, Э.Анхбаяр, Т.Хүүбаяр, Э.Тэлмэн байна. Баярлалаа.

Хурлын дарга Г.Ганболд: Б.Ганбат захиралд баярлалаа. Манай хувьцаа эзэмшлийг бүрдүүлж буй гол багцыг эзэмшиж байгаа Голомт санхүүгийн групп болон Бодь Интернэшнл компаниудын төлөөлөл зааланд хүрэлцэн ирсэн. Ирцийг та бүхэнд танилцууллаа 88 гаруй хувьтай байгаа учир эрх зүйн хувьд хурлыг эхэлж явуулах бүрэн бололцоотой болж байна. Хурлын дэгийг та бүхэнд дахин танилцуулъя. Та бүхэн и-мэйлээр болоод манай цахим хуудас, дан системээр нэвтэрч хурлын материалтайгаа танилцахад дэлгэц дээр харуулж байгаа дэг та бүхний гар дээр очсон. Өнөөдрийн хурлаар бид 7 асуудал хэлэлцэнэ. Үүнд:



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Огноо: Даваа гараг, 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр

Хаана: Шангри-Ла зочид буудлын хүлээн авалтын их танхим

1. Голомт банк ХК-ийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах;
2. Голомт банк ХК-ийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг танилцуулах, батлах;
3. Голомт банк ХК-ийн 2023 оны аудитлагдсан санхүүгийн үр дүн - Хөндлөнгийн аудитын дүгнэлтийг танилцуулах;
4. 2023 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах;
5. 2023 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын тайланг танилцуулах, 2024 оны төсвийг батлах;
6. Төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшигчдийг танилцуулах, батлах;
7. Ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх тухай, батлах.

Албан ёсоор эдгээр асуудлыг хэлэлцэхээр ТУЗ-өөс шийдвэрлэсэн.

Асуудал тус бүрээр хэрхэн танилцуулага өгөх гэдэг дэлгэрэнгүй танилцуулгыг Тооллогын комиссын Дарга Б.Ганбат танилцуулна.

Тооллогын комиссын дарга Б.Ганбат: Санал өгөх заавар алхамууд энгийн. Онлайнаар буюу та бүхэн Голомт банкны албан ёсны цахим хуудсаар саналаа өгөх боломжтой. Хөрөнгө оруулагчид хэсэгт нэвтэрч орохоор Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал гэсэн цонх гарч ирнэ. Ороод 2 сонголттой байгаа хэрэв та Голомт банкны харилцагч бол интернэт банкны эрхээр мөн ДАН системээр нэвтрэх боломжтой. ДАН систем рүү ороход 3 сонголт байгаа, нэг удаагийн кодоор, тоон гарын үсэг мөн интернэт банкны нэвтрэх мэдээлэл ашиглах гэсэн. Г.Ганболд Ерөнхийлөгч хэлсэн байгаа та бүхэн ямар нэгэн электрон төхөөрөмжийн саатал гарвал манай банкны ажилтнууд та бүхэнд туслахаар бэлэн байгаа. ДАН системээр орж байгаа учир өөрийн мэдээллээ өгөхийг зөвшөөрөх хэрэгтэй товчлуур бий. Нэвтэрч ороод манай санал хураалтын цонх нээгдэнэ. Хувьцаа эзэмшигчдийн хурал онлайн буюу шууд дамжуулагдаж байгаа. 2 аргачлалаар саналаа өгнө эхний 3 асуудлыг ердийн санал хураах аргаар саналаа өгнө, Зөвшөөрсөн, Татгалзсан, Түдгэлзсэн. Санал өгөх товчлуурыг дарсны дараа “Амжилттай” гэж хадгалагдана. Сүүлийн асуудал болох ТУЗ-ийн гишүүдийг сонгохдоо кумулятив аргаар сонгож баталгаажуулна. Энэ аргын давуу тал бол нэг нэр дэвшигч болон олон нэр дэвшигчид санал өгөх боломжтой байгаа. Та бүхэн өнөөдрийн 9 нэр дэвшигчдэд саналаа өгөөд санал илгээх товч дээр дарахад мөн “Амжилттай” гэж хадгалагдана. Ингээд та бүхний саналыг онлайнаар хүлээж авч бүртгэнэ. Баярлалаа.

Хурлын дарга Г.Ганболд: Санал өгөхтэй холбоотой асуулт байвал та бүхэн зааланд байгаа дүрэмт хувцастай манай ажилтнуудаас тусламж авч болно. Мөн үүнээс гадна та бүхний суудал дээр манай Голомт банкны 2023 оны жилийн тайлан хэвлэмэл байдлаар очсон байна. Асуулт байхгүй байна гэж ойлголоо. Хурлын хэлэлцэх асуудлын дарааллын дагуу эхний асуудал болох Голомт банкны 2023 оны жилийн үйл ажиллагаа болоод санхүүгийн үр дүнгийн талаарх танилцуулгыг Гүйцэтгэх захирал Норихико Като та бүхэнд хүргэнэ.

Хэлэлцэх асуудал 1. Голомт банк ХК-ийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн танилцуулга.

Танилцуулсан нь:

(Норихико Като англи хэл дээр тайланг танилцуулж, шууд орчуулгатай явав)

Гүйцэтгэх захирал Норихико Като: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа та бүхэнд маш их баярлалаа. Би одоо 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан болон энэ жил хийгдэх ажлуудыг танилцуулах гэж байна. 2023 он бол Голомт банкны хувьд их үр өгөөжтэй, өсөлттэй жил байлаа.

- Макро эдийн засгийн тойм танилцуулав. 2022 онд Монгол улсын эдийн засгийн өсөлт 5.0%-тай байсан бол 2023 онд эдийн засгийн өсөлт 7.0%-д хүрч сайжрав. 2022 онд инфляц 13.2% байсан бол 2023 оны эцэст 7.9% болж буурлаа. Монголбанк энэ онд бодлогын хүүг 13.0 хувьд хэвээр хадгалав. Гадаад валютын нөөц нэмэгдэж 4.9 тэрбум ам.долларт хүрснээр төгрөгийн ам.долларт харьцах ханш харьцангуй тогтвортой байж өмнөх оноос бага зэрэг чангарав. Ам.долларын ханш 2022 оны эцэст 3,444.6 байсан бол 2023 оны эцэст 3,410.7 төгрөгт хүрэв. Банкны тухай хуулийн шинэчлэлттэй холбоотой 2023 онд системийн гурван банк IPO гаргаж 302.6 тэрбум төгрөгийн хөрөнгө татан төвлөрүүлснээр системийн нөлөө бүхий таван банк /+Богд банк/ нээлттэй хувьцаат компани болов.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Огноо: Даваа гараг, 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр

Хаана: Шангри-Ла зочид буудлын хүлээн авалтын их танхим

- 2023 оны эцсээр эдийн засгийн өсөлт 7.0 хувийн өсөлттэй гарав. Үүний 2.6 хувийг уул уурхай, олборлолтын салбар, 2.1 хувийг үйлчилгээ, худалдааны салбар, 1.8 хувийг Тээвэр ба агуулахын салбар бүрдүүлсэн. Хөдөө аж ахуйн салбараас бусад салбар өсөлт үзүүлсэн байна.
- Монгол Банкнаас инфляцыг бууруулах болон төгрөгийн үнэ цэнийг хадгалах зорилгоор бодлогын хүүг 2023 оны турш өндөр хэвээр буюу 13 хувьд хадгалсан ба улсын жилийн инфляц өмнөх оны 13.2 хувиас буурч 7.9 хувьд хүрлээ. 2023 оны эцэст мөнгөний нийлүүлэлтийн өсөлт 26.8 хувьтай гарлаа.
- Санхүүгийн үр дүнг танилцуулъя. Нийт зээлийн хувьд бид бүх сегмент буюу корпорэйт, жижиг дунд, орон сууц болон бусад зах зээлүүд дээр өндөр өсөлтийг үзүүлсэн байгаа. Өсөлтийн хувийг ногооноор харуулж байна. Эх үүсвэрийн хувьд Зээлээр авсанаас бусад бүх төрлүүд өсөлттэй байна. Баруун талын графикт нийт зээл болон эх үүсвэрийн бүтцийг харуулсан бөгөөд үүнээс харвал Голомт банкны бизнес портфолио төрөлжсөн, тогтвортой байна. Энэ зээлийн бүтэц нь Монгол улсын банкны системийн дундаж үзүүлэлттэй төстэй хэмжээнд хүрсэн байгаа. Дэлгэцэнд байгаа эх үүсвэрийн бүтцийн хувьд мөн адил иргэд болон байгууллагын эх үүсвэрийн бүтэц сайн төрөлжсөн.
- Сүүлийн таван жилийн хэмжээнд манай нийт хөрөнгийн хэмжээ өндөр өсөлтийг үзүүлсэн. Ялангуяа өнгөрсөн жил хамгийн өндөр өссөн. Нийт хөрөнгийн хувьд бид зах зээлийн 20 хувийг эзэлж, өсөлтийг үзүүлсэн байна. Нийт актив 1 их наяд төгрөгт хүрсэн. Баруун хэсэгт 2023 оны 4-р сард банк 2022 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 50 төгрөг буюу нийт 40.4 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараасан тухай байна. Энэ жилийн хувьд 2023 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 90 төгрөг буюу нийт 72.8 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараахаар зарлаад байна. Энэ шийдвэр нь бол хувьцаа эзэмшигчдээ урамшуулах зорилготой юм.
- Харилцагчаас татсан эх үүсвэр 39.9 хувиар өсөж 8 их наяд төгрөгт хүрлээ. Нийт өсөлтийн 80%-г байгууллагаас татсан эх үүсвэр, 20%-г иргэдээс татсан эх үүсвэр эзэлж байна. Зах зээлд эзлэх хувь 18.4%-с 20.0% болж өсөв. Нийт зээл 25.2 хувиар өсөж 4.9 их наяд төгрөгт хүрэв. Нийт өсөлтийн 50%-г ритэйл сегментэд олгосон зээл эзэлж байна. Зах зээлд эзлэх хувь 17.3%-с 17.5% болж өсөв.
- Сан, үнэлгээний зардлын өмнөх Үйл ажиллагааны ашиг (свопын нөлөөгүйгээр) 387 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 22.1 хувиар өсөв. Татварын дараах цэвэр ашиг түүхэн дээд хэмжээнд буюу 209.2 тэрбум төгрөгт хүрэв.
- Гол харьцаа үзүүлэлтүүдийн хувьд цэвэр хүүгийн ахиуц 6.5%-д хүрсэн байна. Зардал орлогын харьцаа 44.1%-д хүрч өссөн бөгөөд энэ нь свопын -100 тэрбум төгрөгийн нөлөөг оруулсан үзүүлэлт байна. Чанаргүй зээлийн харьцаа 5.0% болж буурсан байна. Бид хөрөнгийн чанарыг сайжруулахаар ажилласан байгаа энэ нь нийт банкуудын хувьд хоёр дахь бага хувийн үзүүлэлт байгаа. Дундаж өөрийн хөрөнгийн өгөөж 24.1%-д хүрсэн байна.
- Өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа, зээлийн төвлөрөл, төлбөрийн чадвар, гадаад валютын эрсдэлтэй холбоотой Монголбанкны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажиллалаа. 2023 оны эцсээр, банкны нэгж хувьцаанд ногдох ашиг 58%-р өсөж 258.7 төгрөгт хүрлээ.
- Манай банк иргэдийн зах зээлийн хувьд Gen Z үеийнхэн болон шинээр төрж буй үрсийг харилцагчаа болгохоор ажиллаж байгаа. Мөн харилцагчдыг татах, урамшуулах үүднээс Big Loyalty урамшуулалт хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.
- Дижитал чиглэлийн хувьд бид Монголдоо тэргүүлэх дижитал банк болохоор ажиллаж байгаа. Дижитал үйл ажиллагааны хувьд SocialPay 3.0 шинэчилсэн хувилбарыг зах зээлд нэвтрүүлж, энэ нь PMI олон улсын төслийн байгууллагаас шилдэг төсөл шагналыг авсан. Мөн бусад шинэ дижитал бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлж, харилцагчдын үйлдлийг амар хялбар болгох үүднээс дижитал гарын үсгийг зах зээлд нэвтрүүлсэн.
- Худалдаа үйлчилгээний салбар:
 - “Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээл” хөтөлбөрийн хүрээнд 173 тэрбум төгрөгийн зээл олгосон нь нийт зах зээлд 21%-г эзэлж байна.
 - Супермаркет, худалдааны төвийн барилгын санхүүжилтэд зориулж 100 тэрбум төгрөгийн зээл олгож 620 ажлын байр бий болголоо.
 - Худалдагчгүй дэлгүүр Magic Store вендинг машины төлбөр тооцоонд хамтран ажиллах, санхүүжилт олгох гэрээ байгуулав.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Огноо: Даваа гараг, 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр

Хаана: Шангри-Ла зочид буудлын хүлээн авалтын их танхим

- “Сүлжээ дэлгүүрийн авлага барьцаалсан зээл”-н бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлсэн ба 300 гаруй жижиг дунд аж ахуйн нэгжүүд сүлжээ дэлгүүрээс авах авлагаа барьцаалан эргэлтийн хөрөнгөө санхүүжүүлэх боломж бий боллоо.
- Уул уурхайн салбарт
 - Уул уурхайн томоохон компаниудад зориулж 148 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шинээр олгов.
 - Оюутолгойн төсөлд туслан гүйцэтгэгч, бэлтгэн нийлүүлэгчээр ажиллаж буй харилцагч байгууллагуудад 2023 оны байдлаар 347 удаагийн 188 тэрбум төгрөгийн зээлийн санхүүжилт олгон ажиллалаа.
 - Уул уурхайн түүхий эд материалын худалдан авалтад зориулж 7.0 сая ам.доллар буюу 24.1 тэрбум төгрөгтэй тэнцэх SWAP хэлцэл хийж харилцагчийг ханшийн эрсдэлээс хамгааллаа
- Тогтвортой хөгжлийн чиглэлээр МУ-ын банкны салбарыг тэргүүлэн санхүүжүүлсэн (CO2) ялгарлаа хэмжиж, UNEP FI Хариуцлагатай банкны зарчмын тайланд оруулан, Эрнст энд Янг аудитаар баталгаажуулан, тайлагнасан. Хариуцлагатай банкны зарчмын дагуу уур амьсгал болон усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах дунд болон урт хугацааны зорилтоо тодорхойлов. Банк ногоон зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор зээлийн бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлж, нийт 5 төрлийн ногоон зээлийг санал болгож эхлэв. Эрчим хүчний хэмнэлттэй төсөл, хотолбор болон ус, ариун цэврийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудад зориулан Global Climate Partnership Fund, WaterEquity нөлөөллийн сангуудтай хамтран зорилтот ногоон зээлийг олгож эхлэв. Ногоон зээлийн багц 2022 онд 95.8 тэрбум байсан бол 2023 онд 183.04 тэрбум төгрөгт хүрч, нийт зээлийн багцын 4.0%-д хүрлээ.
- Гадаад харилцааны хувьд мөн манай банк тэргүүлэх чиглэлд ажилладаг бөгөөд Монгол улсын экспорт болон дэд бүтэц рүү чиглэсэн төсөл хөтөлбөрүүдэд чиглэн ажилласан. Харилцагчийн арга хэмжээний хувьд “Голомт Алтны Форум”, Financial Managers Conference, Business Conference зэрэг арга хэмжээг жил бүр зохион байгуулдаг. Мөн жижиг, дунд бизнес эрхлэгчдэд үйл ажиллагаагаа өргөжүүлж, бизнесээ дараагийн шатанд гаргахад нь зөвлөн дэмжих зорилгоор “Менторшип” хөтөлбөрийг 2 дахь жилдээ амжилттай хэрэгжүүлэв.
- Эрсдэлийн удирдлагын хүрээнд Кибер аюулгүй байдлын маш олон баталгаажуулалттай. 2023 онд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Мэдээллийн аюулгүй байдлын ISO27001, Хувь хүний өгөгдөл хамгаалах хуулийн шаардлага (GDPR), Төлбөрийн картын аюулгүй байдлын PCI-DSS стандартуудын магадлан аудитыг амжилттай хийлгэсэн. Банк цахим залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор Монголын Банкны Холбоо, Цагдаагийн Ерөнхий Газар, Монгол банктай хамтран “Цахим зөвлөмж” аяныг 2023 онд зохион байгуулсан. Парисын Кибер орчин дахь аюулгүй байдлыг хангах харилцан итгэлцлийн уриалгад нэгдэв.
- Дотоод үйл ажиллагааны хувьд Банк нь “Ажилтан төвтэй банк” бодлогын хүрээнд мэргэжлийн ёс зүйтэй, банкны үнэт зүйлд суурилсан, ажилтан бүрд ээлтэй хүний нөөцийн менежментийн тогтолцоог бий болгон урт хугацаанд, тогтвортой өсөж хөгжих боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.
- Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн “Great place to work institute”-ээс “Ажиллахад хамгийн таатай газар” батламжийг Голомт банк 2022 онд Монгол Улсын банк, санхүүгийн салбараас анхлан авч байсан бол 2023 онд амжилтаа дахин бататгаж, уг батламжийг хоёр жил дараалан авсан анхны байгууллага боллоо.
- 2024-2026 оны бизнес төлөвлөгөөний талаар танилцуулав:
- Банк нь 2022-2023 онуудад чанаргүй зээлийн багцаа бууруулж, амжилттай IPO хийснээр өөрийн хөрөнгө, ашигт ажиллагаагаа сайжруулж чадсан билээ. Үүнд тулгуурлан банк 2024 он болон түүнээс цааших жилүүдэд актив, орлогын хэмжээ, ашигт ажиллагааны өсөлтийг шинэ түвшинд хүргэж салбартаа хоёр дахь том мөн ашигт ажиллагаагаараа хоёр дахь банк болох зорилтыг



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Огноо: Даваа гараг, 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр

Хаана: Шангри-Ла зочид буудлын хүлээн авалтын их танхим

дэвшүүлж ажиллана. Бид 2024-2026 онд дундаж өөрийн хөрөнгийн огоожийг 20%-аас дээш, ногдол ашгийн хувьд банкны бизнесийн гүйцэтгэл, боломж, орчин, стратеги зэргийг харгалзан хувьцаа эзэмшигчдийн өгөөжийг тогтвортой байлгах зорилт тавьж байна.

- 2024 оны бизнес төлөвлөгөөний гол чиглэлүүд :
 - Дижиталчлалыг эрэлхийлэх
 - Зээлийн шийдвэр гаргалтын хурдыг нэмэгдүүлж, зээлийн удирдлагыг бэхжүүлэх
 - Шинэ зээлийн болон бусад бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх
 - ЖДҮ бизнес болон ритэйл бизнесээ бэхжүүлэх,
 - Тогтвортой санхүүжилтийг дэмжих
 - Урт хугацааны хөрөнгө босгох
 - Хөрөнгийн зах зээлд мэдээллийн ил тод харилцаа холбоог бий болгох
- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 12-р сарын 28-ны өдрийн ээлжит хурлын 00/35 тоот тогтоолоор 2024 оны 1-р сарын 15-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлэх Банкны бүтэц, зохион байгуулалт шинэчлэн батлагдлаа. Үүнд:
 - “Дижитал шилжилтийн газар”-ыг шинээр байгуулах. Энэхүү газар нь Процесс удирдлагын хэлтэс, Дата удирдлагын хэлтэс, Төслийн удирдлагын хэлтэс гэсэн 3 хэлтэстэй байна.
 - “Харилцагчийн бүртгэлийн газар”-ыг шинээр байгуулах. Энэхүү газар нь Зээлийн хувийн хэргийн хэлтэс, Харилцагчийн хувийн хэрэг хяналтын хэлтэс, Архив ложистикийн албатай байна.
 - “Зээл цуглуулах газар”-ыг шинээр байгуулах. Энэхүү газар нь Утсаар цуглуулах хэлтэс, Биечлэн цуглуулах хэлтэс, Тусгай активын хэлтэс, Бүртгэлийн хэлтэс, Хөрөнгийн менежментийн албатай байна.
 - “Харилцагчийн үйлчилгээний газар”-ыг шинээр байгуулах. Энэхүү газар нь Харилцагчийн үйлчилгээний хэлтэс, Харилцагчийн туршлагын хэлтэс, Гомдлын удирдлагын хэлтэстэй байна.
 - “Зээлийн газар”-ын бүтцэд өөрчлөлт оруулж, “Бизнес процесс менежментийн газар”-ыг татан буулгав. Мөн хэлтэс, албадын түвшинд өөрчлөлтүүдийг оруулж бүтэц зохион байгуулалтыг шинэчлэв.
- ТУЗ-ийн шийдвэрээр ногдол ашигт нэгж энгийн хувьцаанд 90 төгрөг, нийт 72.8 тэрбум төгрөг олгохоор шийдвэрлэв. Энэ нь МБ-ны тайлангаарх цэвэр ашгийн 40.3 хувьтай тэнцүү байна.
- Ногдол ашгийн бодлого: Бид банкны бизнесийн гүйцэтгэл, боломж, орчин, стратеги зэргийг харгалзан хувьцаа эзэмшигчдийн өгөөжийг тогтвортой байлгах бодлого барьж ажиллана.

Хурлын дарга Г.Ганболд: Като захиралдаа баярлалаа. Банкны хувьд 2023 он бүхэлдээ өсөлтийн жил болсон. Банкны үндсэн гурван үзүүлэлт эх үүсвэр, зээл, нийт активын хэмжээ гурвуулаа зэрэг өссөн цорын ганц банк болсон. 2024 онд энэ өсөлтүүдээ бүгдийг нь хадгална. Банк 2024 онд үйл ажиллагаа, бүтэц, ашгийн хувьд өсөлт, тэлэлтийн жил болгохоор зорилт тавиад, эхний улирлын байдлаар тавьсан зорилтуудаа бүрэн хэрэгжүүлээд явж байна. Одоо ТУЗ-өөс 2023 оны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнд хийсэн дүгнэлтийг танилцуулна. ТУЗ-ийн дүгнэлтийг ТУЗ-ийн гишүүн Ж.Үнэнбат танилцуулна.

Хэлэлцэх асуудал 2. Голомт банк ХК-ийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах.

Танилцуулсан нь:

ТУЗ-ийн гишүүн Ж.Үнэнбат: Голомт банкны эрхэм хувьцаа эзэмшигчид болон энэ хуралд хүрэлцэн ирсэн та бүхэнд өглөөний мэнд хүргэе. ТУЗ бол банкныг стратеги, удирдлагаар хангадаг, санхүүгийн үзүүлэлт, эрсдэлийн үзүүлэлт дээр хяналт тавих үүрэгтэй. Өнгөрсөн жил стратегийн хувьд бизнес төлөвлөгөө, бодлого болон үйл ажиллагааны төлөвлөгөө зэрэг бодлогыг баталсан. ТУЗ нь улирал тутам бизнес төлөвлөгөөний гүйцэтгэл, төсвийн зарцуулалтыг хянадаг.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Огноо: Даваа гараг, 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр

Хаана: Шангри-Ла зочид буудлын хүлээн авалтын их танхим

Голомт банкны 2023 оны стратеги төлөвлөгөө, үйл ажиллагааны төсвийг 2023 оны 02 сарын 10-ны өдөр 00/03 тоот Тогтоолоор батлан Гүйцэтгэх удирдлагад хэрэгжүүлэх үүргийг өгсөн. Нийт 10 бизнес төлөвлөгөө, 11 бодлогын бичиг баримт батлав.

Аудитын хороогоор сар бүр, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар улирал бүр Бизнес төлөвлөгөөний гүйцэтгэл, төсвийн зарцуулалтыг хянадаг.

Бидний гол анхаардаг зүйл бол эрсдэлийн удирдлага. Эрсдэлийн удирдлагаар банкны хөрөнгийг аль болох үр ашигтай зарцуулж, эрсдэлд оруулахгүй байх үйл ажиллагаа явуулдаг. Энэ дундаа зээлийн төвлөрлийн эрсдэл, зах зээлийн эрсдэл, хөрвөх чадварын эрсдэл, өөрийн хөрөнгийн хүрэлцээний эрсдэл зэрэг 40 төрлийн эрсдэлийн лимит, хэмжүүр үзүүлэлтүүдийг тогтоож, тогтмол хянаж ажилласан.

Голомт банкны 2023 оны стратеги төлөвлөгөөтэй уялдсан Эрсдэлийн удирдлагын бодлогыг тодорхойлж, эрсдэлийн лимитүүдийг ТУЗ-өөс 2023.12.28 өдрийн 00/37 тоот Тогтоолоор баталсан.

Эрсдэлийн лимитүүдийг:

1. Зээлийн төвлөрлийн эрсдэлүүд
2. Зээлийн багцад эзлэх эдийн засгийн салбарын төвлөрлийн эрсдэл
3. Зээлийн чанарын эрсдэл
4. Зах зээлийн эрсдэл
5. Хөрвөх чадварын эрсдэл
6. Өөрийн хөрөнгийн хүрэлцээний эрсдэл
7. Үйл ажиллагааны эрсдэл

зэргийг хамарсан нийт 48 эрсдэлийн лимитийг тогтоож

Эдгээр эрсдэлийн хязгаарлалт хэмжүүрүүдийн хэрэгжилтийг Төлөөлөн удирдах зөвлөлийн Эрсдэлийн удирдлагын хороогоор тогтмол хянаж ажилласан.

Баласын гол үзүүлэлт болох банкны актив 2.6 их наяд төгрөгөөр нэмэгдэж нийт 11.6 их наяд төгрөгт хүрлээ. Түүнээс харилцагчийн эх үүсвэр 2.3 их наядаар өсөж нийт 8 их наяд төгрөгт хүрлээ.

Нийт зээлийн багц 980 тэрбум төгрөгөөр /25.2%/ өсөв. ҮЦ-ны танилцуулгад 438 тэрбум төгрөгөөр өсгөхөөр тусгасантай харьцуулахад 2.2 дахин их өсөлтийг үзүүлсэн байна.

Чанаргүй зээлийн хувь 5.0% буюу ҮЦ-ны танилцуулгад тусгасан 6.4%-иас сайн үзүүлэлттэй.

Тэнцвэртэй, төрөлжүүлсэн зээлийн багцын бүтцийг хадгалж ажиллав.

Сангаас хаасан зээлийн танилцуулгыг тайлагнаж.

Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.1.4-т “Банкны үнэлгээгээр цаашид эргэн төлөгдөхгүй байх эрсдэлтэй гэж тооцогдсон муу ангилалтай активыг” тэнцлээс хасах тухай заасны дагуу дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

- Нас барсан;
- Шүүхийн шийдвэр гарсан 180 хоногт төлөлтгүй;
- Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа (ШГА) статустай;
- 90-с дээш хоног эрэн сурвалжилсан;
- Харилцагчийн зээлүүдийн эрсдэлийн сан 100%-тай байгуулсан;
- Барьцаа хөрөнгөгүй;
- Банк цуглуулах ажлыг үргэлжлүүлэх хөрөнгөтэй;
- Харилцагчдын дансанд сүүлийн 6 сард орлого ороогүй зээлүүдийг авч үзсэн. Тодруулбал:
 - Сүүлийн 6 сарын орлого 10,000₮-с бага;
 - Сүүлийн 6 сарын орлого / зээлийн үлдэгдэл 5%-с бага;
- Харилцагчдын бусад банкны зээлүүд чанаргүй ангилалтай байх;

Ашигт ажиллагааны хувьд банк нь 2023 онд түүхэн өндөр зорилгоор давсан ашиг хийж ажиллаа.

Үйл ажиллагааны ашиг 387 тэрбум төгрөгт хүрч, татварын өмнөх ашиг 266 тэрбум, татварын дараах ашиг 209 тэрбум төгрөгийн ашигтай оныг үдлээ.

ТУЗ-ийн гишүүн Ж.Үнэнбат: Эдгээр бүх санхүүгийн үр дүн болоод үйл ажиллагааны үр дүн мөн хөндлөнгийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайланг үндэслэн ТУЗ-өөс Голомт банкны 2023 оны тавьсан зорилго зорилтууддаа амжилттай сайн биелүүлж ажилласан гэж дүгнэсэн болно. Анхаарал хандуулсанд баярлалаа.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Огноо: Даваа гараг, 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр

Хаана: Шангри-Ла зочид буудлын хүлээн авалтын их танхим

Хурлын дарга Г.Ганболд: Тус дүгнэлттэй холбогдуулаад шийдвэр гарах ёстой. Энэ өмнө нь та бүхэнд хүргэгдсэн байгаа. Өнөөдрийн хурлаараа бид баталгаажуулах ёстой байгаа.

Тогтоолын төсөл

Голомт банкны 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.7, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, Голомт банкны дүрмийн 8 дугаар зүйлийн 8.2.8 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 04 сарын 15-ны ээлжит хурлын санал хураалтыг тус тус үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

1. “Голомт банк” ХК-ийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн үр дүн, түүнийг баталгаажуулсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

Хэлэлцэх асуудал 3. 2023 оны аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулав.

Танилцуулсан нь:

Кэй Пи Эм Жи Аудит ХХК-ийн Ерөнхий захирал Г.Соёлмаа: Сайн байна уу, Голомт банкны Хувьцаа эзэмшигчдийн хуралд хүрэлцэн ирсэн та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Намайг Г.Соёлмаа гэдэг би Кэй Пи Эм Жи Аудит ХХК-ийн Ерөнхий захирал байна. Манай компани Голомт банкны 2023 оны санхүүгийн тайлангийн аудитыг хийж гүйцэтгэсэн. Бид аудитын төлөвлөлт болон үр дүнг танилцуулах явцад аудитын хороонд маш дэлгэрэнгүй танилцуулгуудыг хийсэн. Өнөөдөр товч байдлаар танилцуулъя.

Аудитын багийн бүрэлдэхүүнийг танилцуулав.

Бид Голомт Банк ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд ба бусад тайлбар мэдээллүүдийг агуулсан тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит

хийсэн.

Бидний дүгнэлтээр, санхүүгийн тайлан нь Банкны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

Хурлын дарга Г.Ганболд: Баярлалаа. Энэхүү хөндлөнгийн хараат бус дүгнэлт бол ТУЗ-ийн хурал дээр илүү дэлгэрэнгүй байдлаар танилцуулагдсан байгаа. Ингээд Голомт банкны 2023 оны санхүүгийн болон үйл ажиллагаатай холбоотой тайлан, тайланд хийсэн дүгнэлтүүдийг та бүхэнд танилцууллаа. Хуралд манай ТУЗ-ийн бусад гишүүд, мөн нэлээд хэмжээний хувьцаа эзэмшигчид онлайнаар оролцож байгаа. Та бүхэн асуулт асуух эрх бүрэн нээлттэй байгаа. Дараагийн шийдвэрийг та бүхэнд танилцуулъя. Ногдол ашиг тараах эсэхийн шийдвэрлэсэн ТУЗ-ийн тогтоол.

Хэлэлцэх асуудал 4. 2023 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулав.

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, дахь хэсэг, Голомт банкны дүрмийн 5 дугаар зүйлийн 5.3., 9 дүгээр зүйлийн 9.2.12. дэх хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн ээлжит бус хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Голомт банкны 2023 оны үйл ажиллагааны ашгаас нэгж хувьцаанд 90 төгрөгөөр тооцож, ногдол ашиг хуваарилахыг зөвшөөрсүгэй.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Огноо: Даваа гараг, 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр

Хаана: Шангри-Ла зочид буудлын хүлээн авалтын их танхим

Санхүүгийн Зохицуулах Хорооны “Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай” тогтоолын 1-д заасны дагуу Хувьцаат компани нь зөвхөн эрх бүхий зуучлагч байгууллага болох “ҮЦТХТ” ХХК-иар дамжуулан ногдол ашиг хуваарилах гэрээний үндсэн дээр тараана. Ногдол ашиг тараахад зохицуулагч байгууллагын зөвшөөрөл шаардлагатай ба одоо энэхүү зөвшөөрөл хүлээгдэж байна, 2023 оны 04 сардаа багтаан тараах хүлээлттэй байна.

Хурлын дарга Г.Ганболд: Энэ шийдвэр өмнө нь та бүхэнд хүрсэн байгаа. Нэгж хувьцаанд 90 төгрөгийн ногдол ашиг буюу нийт 72,7 тэрбум төгрөгийн ногдол ашиг хуваарилхаар шийдвэрлэсэн байгаа. Монголбанк ногдол ашиг тараах зөвшөөрлийг өгдөг. Энэ зөвшөөрөл хүлээгдэж байгаа бөгөөд энэ долоо хоногтоо багтаж, хуваарилагдана гэж найдаж байна. СЗХ-ны зохицуулалтаар 04 дүгээр сарын 30-ны дотор Хувьцаа эзэмшигчдэд тараагдах ёстой байгаа. Өнгөрсөн жилийн ногдол ашигтай харьцуулбал хувьцааны өгөөж өссөн сайн үзүүлэлттэй байна.

Одоо хэлэлцэх асуудлын дарааллаар ТУЗ-ийн ажлын тайлан, 2024 оны төсвийг та бүхэнд ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга З.Солонго танилцуулна.

Хэлэлцэх асуудал 5. 2023 оны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ажлын тайлан, 2024 оны төсвийг танилцуулж батлах.

Танилцуулсан нь:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга З.Солонго: Сайн байцгаана уу, миний бие З.Солонго, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга байна. ТУЗ-ийн 2023 оны ажлын тайлан болон 2024 оны цалингийн төсвийг батлуулахаар саналыг танилцуулна.

- Голомт банкны засаглалын бүтцээр Хувьцаа эзэмшигчдээс Төлөөлөн удирдах зөвлөлийг томилдог. ТУЗ нь дөрвөн байнгын хороотой, Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хороо, Засаглал, ёс зүй, цалин урамшууллын хороо, Нэр дэвшүүлэх хороо.

2023 онд Голомт банкны Төлөөлөн удирдах зөвлөл нь:

- 4 ээлжит
- 11 ээлжит бус хурал хуралдуулж (нийт 15)
- 66 асуудал хэлэлцэж
- 40 тогтоол (шийдвэр) гаргасан байна.
- Шийдвэрүүдийг ангилж үзвэл

Стратеги, хөрөнгө оруулалттай холбоотой:

- нийт ТУЗ-ийн хурал, Хороодын хурлаар 20 гаруй хэлэлцүүлэг болсны үндсэн дээр 23 шийдвэр гаргасан байна. /Баримтлах стратеги, бизнес төлөвлөгөө, төсөв багтана/

Дотоод үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт сайжруулах:

- нийт 12 шийдвэр гаргаж хэрэгжилтийг хянан ажиллаж байна.

Бодлогын баримт бичиг, дүрэм журам, засаглалыг сайжруулах:

- нийт 10 бодлого журмыг сайжруулан шинэчилсэн байна.

- **Аудитын хорооны бүтэц бүрэлдэхүүн:**

- Хорооны Дарга ТУЗ-ийн Хараат бус гишүүн Жэймс Б. Двайер
- 5 гишүүний дийлэнх буюу 3 гишүүн ТУЗ-ийн Хараат бус гишүүн.

Хорооны хурал:

- Аудитын хороо нь 2023 онд нийт 10 удаа хуралдаж дундаж ирц 92%-тай хуралдсан
- нийт 37 асуудал хэлэлцэж холбогдох зөвлөмж, шийдвэрийг гаргасан



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Огноо: Даваа гараг, 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр

Хаана: Шангри-Ла зочид буудлын хүлээн авалтын их танхим

Хурлын дийлэнх асуудлууд аудит шалгалтын тайлаг дүгнэлт, дотоод аудитын үйл ажиллагаа, аудитын төлөвлөгөөтэй холбоотой асуудал эзэлсэн.

Дараах 30-аад хувь нь банкны бизнес төлөвлөгөө, санхүүгийн үр дүнг баталгаажуулсан байдал орсон бол үлдсэн хувь нь зохицуулагч байгууллагын хяналт шалгалт, хондлогийн аудитын үүрэг зөвлөмжийн тухай хэлэлцсэн байна.

- **Эрсдэлийн удирдлагын хорооны** Бүтэц бүрэлдэхүүн:

Хорооны Дарга ТУЗ-ийн Хараат бус гишүүн Александр Пикер

5 гишүүний дийлэнх буюу 3 гишүүн ТУЗ-ийн Хараат бус гишүүн.

Хорооны хурал:

- 2023 онд нийт 25 удаа буюу дунджаар сард 2 удаа хуралдлаг
- нийт 96 асуудал хэлэлцэж, холбогдох зөвлөмж, шийдвэрийг гаргасан

Хэлэлцсэн асуудал:

- 70% нь 20 тэрбум тогрог буюу түүнээс зээлтэй групп компаниудын хүсэлтийг шийдвэрлэсэн Зээлийн хорооны хяналт
- 20% нь Эрсдэлийн тайлан мэдээлэл, эрсдэлийн удирдлага бодлого
- 10% нь бусад цаг үеийн асуудал, мэдээлэл
- **Засаглал, Ёс зүй, цалин урамшуулал**, нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагаанаас нэр дэвшүүлэх үйл ажиллагаатай холбоотой хэсгийг салган ТУЗ-ийн 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн тогтоолоор тусгаарлан байгуулсантай холбоотойгоор тус хороог өөрчлөн байгуулав.

Хорооны чиг үүрэг:

- Засаглал, Ёс зүй, Цалин урамшууллын үйл ажиллагаа

Бүтэц бүрэлдэхүүн:

- Хорооны Дарга ТУЗ-ийн хараат бус гишүүн Жэймс Б. Двайер
- 3 гишүүний дийлэнх буюу 2 гишүүн ТУЗ-ийн Хараат бус гишүүн

Хорооны хурал:

- 2023 онд нийт 3 удаа хуралдсан
- нийт 7 асуудал хэлэлцэж холбогдох зөвлөмж, шийдвэрийг гаргасан

Хэлэлцсэн асуудал:

- Хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, төсөв
- Цалин урамшууллын бодлого, ГУ багийн гүйцэтгэл, урамшуулал
- **Нэр дэвшүүлэх хорооны тайланг танилцуулав:**

ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, Ёс зүй, Цалин урамшуулал, Нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагаанаас нэр дэвшүүлэх үйл ажиллагаатай холбоотой хэсгийг салган Нэр дэвшүүлэх хороог ТУЗ-ийн 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн тогтоолоор тусгаарлан байгуулав.

Хорооны чиг үүрэг:

- Нэр дэвшүүлэх үйл ажиллагаа

Бүтэц бүрэлдэхүүн:

- Хорооны Дарга ТУЗ-ийн Хараат бус гишүүн Александр Пикер
- 3 гишүүний дийлэнх буюу 2 гишүүн ТУЗ-ийн Хараат бус гишүүн

Хорооны хурал:

- 2023 онд нийт 6 удаа хуралдсан
- нийт 10 асуудал хэлэлцэж холбогдох зөвлөмж, шийдвэрийг гаргасан

Хэлэлцсэн асуудал:

- Бүтэц зохион байгуулалт, Хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, төсөв



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Огноо: Даваа гараг, 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр

Хаана: Шангри-Ла зочид буудлын хүлээн авалтын их танхим

- ГУ-ийн баг, ТУЗ-ийн гишүүн нэр дэвшүүлэх

ТУЗ нь 2023 онд нийт 59 удаа хуралдсан буюу дундажаар долоо хоног бүр нэг хуралдсан үзүүлэлттэй байна. ТУЗ-ийн гишүүд маань их ачаалалтай ажилладагийн илэрхийлэл мөн.

ТУЗ-ийн гишүүн байх нь Томилгоот ажил учраас ТУЗ-ийн гишүүд ямар нэгэн амралтын мөнгө, урамшуулал хүртдэггүй ба 2024 оны ТУЗ-ийн нийт төсөв 1,199 сая төгрөг байна. Үүнийг батлуулахаар санал оруулж байна.

Хурлын дарга Г.Ганболд: Манай ТУЗ нийт 9 гишүүнтэй үүнээс 5 гишүүн ердийн, 4 гишүүн хараат бус байна. Өнөөдрийн батлах асуудал бол 2024 оны төсөв байгаа. Та бүхэнд шийдвэрийг уншиж танилцуулъя.

Тогтоолын төсөл

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны төсөв батлах тухай

Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.9 дэх заалт, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, 62.1.15 дахь заалт, Голомт банкны дүрмийн 8.2.12 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 04 сарын 15-ны өдрийн ээлжит хурлын санал хураалтыг тус тус үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

1. “Голомт банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны төсвийг хавсралтаар баталсугай.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн	Цалин 2024 төсөв	Жилд нийт	1,199 сая ₮
---	---------------------	-----------	-------------

Хэлэлцэх асуудал 6. Голомт банкны ТУЗ-ийн гишүүдийг сонгох.

Танилцуулсан нь:

Гүйцэтгэх захирлын орлогч А.Одонбаатар: Энэхүү танхимд хүрэлцэн ирсэн та бүхэнд болон онлайнаар оролцож байгаа хувьцаа эзэмшигчдэдээ энэ өдрийн мэндийг хүргэе. Миний бие ирэх 3 жилд Голомт банкныг удирдан чиглүүлэх, стратегийн шийдвэр гаргах, засаглалын чухал нэгж болох ТУЗ-ийн сонгуульд нэр дэвшигчдийг танилцуулна. Энэ удаагийн сонгуульд 5 ердийн гишүүд, 4 хараат бус гишүүд нэр дэвшиж байна.

1. Ердийн гишүүнд нэр дэвшигчид:

Ч.МӨНХЦЭЦЭГ

Боловсрол:

- Зөвлөлтийн 3-р дунд сургууль, (1978-1988)
- Политехникийн ИС, УУЦМеханик инженер, (1988-1993)
- АНУ-ын Жонс Хопкинсийн ИС, Бизнесийн Удирдлагын магистр, (1999-2001)
- АНУ-ын Харвардын ИС, Удирдлагын манлайллын хөтөлбөр, (2015)
- Англи улсын Оксфордын ИС, Удирдлагын хөгжлийн хөтөлбөр, (2016)

Ажлын туршлага:

- Монголын Хөрөнгийн бирж, Гадаад харилцааны албаны дарга, (1996-1998)
- Дэлхийн банк, Төслийн ко-ординатор, (2004)
- Азийн сан, Төслийн стратеги, хөгжлийн хэлтсийн дарга, (2004-2007)
- Нэпко хэвлэлийн компани, Гүйцэтгэх захирал, (2007-2010)
- Тойм сэтгүүл, Эрхлэгч, Үүсгэн байгуулагч, (2010-2012)
- Улаанбаатар дах Олон Улсын сургууль, ТУЗ-ийн гишүүн, (2004-2014)
- Монгол Масс Медиа ХХК, ТУЗ-ийн гишүүн, (2014-2018)
- Голомт банк, ТУЗ-ийн ердийн гишүүн, дарга (2012 - одоог хүртэл)



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Огноо: Даваа гараг, 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр

Хаана: Шангри-Ла зочид буудлын хүлээн авалтын их танхим

Ж.ҮНЭНБАТ:

Боловсрол:

- Нийслэлийн 30 дугаар болон 14 дүгээр дунд сургууль, (1970-1980)
- ЗХУ-ын Москва хотын эдийн засаг статистикийн ДС, Эдийн засагч, статистикч, (1980-1985)
- АНУ-ын Колумбын их сургууль, Олон улсын харилцааны мастер (1993-1994)

Ажлын туршлага:

- Монгол банк, Мэргэжилтэн, Газрын дарга, (1990-1996)
- Монгол банк, Ерөнхийлөгч (1996-2000)
- Азийн хөгжлийн банк, МУ-ыг хариуцсан Захирагч, (1998-1999)
- Дэлхийн банк, МУ-ыг хариуцсан Захирагч, (1998-1999)
- Монголын банкны холбоо ТББ, Гүйцэтгэх захирал, (2000-2006, 2015-2020)
- Монгол банк, Хяналтын зөвлөлийн гишүүн, (2004-2016)
- Монголын Уул уурхайн корпорац, ТУЗ-ийн хараат бус гишүүн, (2010-одоог хүртэл)
- АПУ ХК, ТУЗ-ийн хараат бус гишүүн, (2015 – одоог хүртэл)
- Нээлттэй нийгэм форум ТББ, Удирдах зөвлөлийн гишүүн, (2016 – одоог хүртэл)
- Голомт банк, ТУЗ-ийн хараат бус гишүүн, (2011-2019)
- Голомт банк, ТУЗ-ийн ердийн гишүүн, (2020 – одоог хүртэл)

О.ГАНЖОЛОО

Боловсрол:

- Монгол-Оросын хамтарсан 2 дугаар дунд сургууль, (1984-1994)
- МУИС, Банк, Санхүү, (1994-1997)
- ХБНГУ-ын Чөлөөт ИС, Бизнесийн Удирдлагын магистр, (1997-2002)
- ХБНГУ-ын Чөлөөт ИС, Эдийн засгийн шинжлэх ухааны доктор, (2006-2008)
- Монгол Улсын мэргэшсэн нягтлан бодогч

Ажлын туршлага:

- Голомт банк, Санхүүгийн хяналтын газар, мэргэжилтэн, (2003)
- Бодь групп ХХК, ХБНГУ дах Төлөөлөгчийн газар, ажилтан, (2004-2005)
- ПрайсУотерХаус Куперс Аудит ХХК, ХБНГУ, Зөвлөх, (2008-2010)
- ПрайсУотерХаус Куперс Аудит ХХК, Монгол Улс, Ахлах зөвлөх, (2010-2011)
- Бодь интернэшнл ХХК, Санхүү хариуцсан захирал, (2011-2018)
- Голомт санхүүгийн нэгдэл ХХК, Гүйцэтгэх захирал, (2016-одоог хүртэл)
- Голомт банкны ТУЗ-ийн ердийн гишүүн (2022-одоог хүртэл)

Д.МӨНХТӨР

Боловсрол:

- Завхан аймгийн 3-р дунд сургууль, (1983-1993)
- МУИС, Банк, Санхүү, Бакалавр, (1993-1997)
- АНУ-ын Оклахомагийн ИС, Бизнесийн Удирдлагын магистр, (2007-2009)

Ажлын туршлага:

- Голомт банк, Эдийн засагч, (1997-1999)
- Голомт банк, Зээлийн газрын захирал, (1999-2007)
- Голомт банк, Бүртгэл тооцооны газрын захирал, (2009-2011)
- Голомт банк, Үйл ажиллагаа хариуцсан тэргүүн дэд захирал, (2011-2014)



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Огноо: Даваа гараг, 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр

Хаана: Шангри-Ла зочид буудлын хүлээн авалтын их танхим

- Бодь Интернэшнл ХХК, Дэд захирал, Төслийн удирдагч, (2014-2019)
- Цэцэнс Майнинг Энд Энержи ХХК, Гүйцэтгэх захирал, (2019-одоог хүртэл)
- Голомт банк, ТУЗ-ийн ердийн гишүүн, (2012-одоог хүртэл)

УРС Э.ШВАРЦЕНБАХ

Боловсрол:

- Швейцари улсын Цюрихын худалдааны коллеж (1966-1968)
- Канад улсын Гэгээн Франсис Хавизэрын Их сургуулийн Хуулийн сургуулийн -Хүндэт доктор (2000)

Ажлын туршлага:

- Швейцарийн холбооны банк, Гадаад арилжааны хэлтэс (1968-1973)
- Швейцар Улс, Бүс нутаг дахь Монгол улсын өргөмжит Консул (2010-одоог хүртэл)
- Швейцар Улсын 5 од бүхий тансаг зэрэглэлийн Dolder Grand зочид буудлын эзэмшигч
- Үл хөдлөх хөрөнгийн болон Санхүүгийн компанийг үүсгэн байгуулж, амжилттай удирдаж байна.
- Голомт банк, ТУЗ-ийн ердийн гишүүн, (2011-одоог хүртэл)

Хараат бус гишүүнд нэр дэвшигчид:

ЖЭЙМС Б.ДВАЙЕР

Боловсрол:

- АНУ-ын Нотр Дамын ИС, Бизнесийн удирдлагын бакалавр (1961-1965)
- АНУ-ын Колумбын ИС-ийн Бизнесийн сургууль, Бизнесийн удирдлагын магистр (1968-1970)

Ажлын туршлага:

- UBS банк, Компанийн нэгдэл, компани худалдан авах процесс хариуцсан захирал (1988-1991)
- KPMG Зөвлөх үйлчилгээ, Хөрөнгө оруулалтын банкны зөвлөх (2001-2003)
- Хойд Америк-Монголын бизнес зөвлөл, Үйл ажиллагаа хариуцсан захирал (2003-2007)
- Монголын урлагийн зөвлөл, Хөгжлийн зөвлөл (2007-2011)
- Жиант Степпес оф Жазз, Дэд тэргүүн (2006-2012)
- Эдийн засаг, бизнесээр мэргэшиж буй оюутнуудын олон улсын холбооны Монгол дахь зөвлөл, ТУЗ-ийн дэд дарга (2009-2012)
- Монголын хөгжлийн нөөц ХК, ТУЗ-ийн гишүүн (2010-2014)
- Монголын бизнесийн зөвлөлийн Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн дэд дарга (2007-2017)
- Мандал даатгал ХК, ТУЗ-ийн хараат бус гишүүн (2012-одоог хүртэл)
- Монголын хөгжлийн групп, ТУЗ-ийн хараат бус гишүүн (2014-одоог хүртэл)
- Голомт банк, ТУЗ-ийн хараат бус гишүүн (2017-одоог хүртэл)
- Монголын финтек групп ХК, ТУЗ-ийн хараат бус гишүүн (2018-одоог хүртэл)
- Монголын бизнес мэдээллийн сан, Хамтрагч/ТУЗ-ийн гишүүн (2018-одоог хүртэл)

АЛЕКСАНДР ПИКЕР

Боловсрол:

- Австри улсын Зальцбургийн ИС, Бизнес, Хуулийн чиглэлээр магистр, доктор (1982-1989)

Ажлын туршлага:

- Австри улсын Die ERSTE банк, Төслийн санхүүжилтийн ахлах ажилтан (1990-1993)
- Австри улсын хяналтын банк, ЗХУ хариуцсан ахлах ажилтан (1993)
- ОХУ-ын Москвагийн олон улсын банк, Байгууллагын банкны газрын ахлах менежер, Захирал, Эрсдэл хариуцсан захирал (1994-1999)
- Польш улсын BPH банк, Үйл ажиллагаа хариуцсан захирал, Эрсдэл хариуцсан захирал (1999-2004)
- Серби улсын Unicredit банк, Гүйцэтгэх захирал (2004-2007)



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Огноо: Даваа гараг, 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр

Хаана: Шангри-Ла зочид буудлын хүлээн авалтын их танхим

- Казакстан улсын JSC ATF банк, Гүйцэтгэх захирал (2007-2010)
- Европын Unicredit групп, Дэд ерөнхийлөгч (1994-2011)
- Пуро Alpe-Adria банкны Чех, Босни ба Херцеговина, Австри улс дах салбаруудын Гүйцэтгэх захирал (2011-2015)
- Итали улсын Нуро банк, ТУЗ-ийн дарга (2014-2015)
- Серби улсын Komercijalna банк, Гүйцэтгэх захирал (2015-2017)
- Transparency International-н Австрийн салбар, Гүйцэтгэх захирал (2018-2019)
- Герман улсын AlixPartners, Хараат бус гэрээт ажилтан (2018-2019)
- Австри улсын BCB4U, Гүйцэтгэх захирал (2019)
- Pendl & Pischwanger, ТУЗ-ийн зөвлөх гишүүн (2019-2023)
- Австри улсын Крипто Бирж, Зөвлөх (2020-2021)
- Узбекистан улсын Iproteka банк, Хяналтын зөвлөлийн дарга (2020-2023)
- Голомт банк, ТУЗ-ийн хараат бус гишүүн (2021-одоог хүртэл)
- Бүгд найрамдах Молдав Улсын Moldindconbank банкны Гүйцэтгэх захирал (2023-одоог хүртэл)

РОБЕРТ В. ВАН ЗВИТЕН

Боловсрол:

- Нидерландын Хаант Улсын Лейдны ИС, Хуульч (1980-1986)
- АНУ-ын Колумбын их сургууль, Хууль зүйн магистр (1987-1988)
- Нидерландын Хаант Улсын Лейдны ИС, ОУ-ын эдийн засгийн магистр (1986-1991)
- АНУ-ын Чикаго их сургууль, Бизнесийн удирдлагын магистр (1994-1996)

Ажлын туршлага:

- НХУ-ын Royal Vopak, Хуульч, Евро бүсийн хариуцсан менежер, (1985-1990)
- ABN Amro Bank, АНУ, БНСУ, НХУ-ууды салбаруудад дэд ерөнхийлөгч (1990-1998)
- General electric, Санхүүч (1998-2002)
- Lehman brothers, Лондон, Нью-Йорк, Франкфурт, Токио салбаруудад Үйл ажиллагаа хариуцсан захирал (2002-2005)
- Сингапурын хөрөнгийн бирж, Санхүүч хариуцсан захирал (2006-2007)
- Стандарт банк, Сингапур салбар (2007-2008)
- Азийн хөгжлийн банк, Хувийн салбарын хөрөнгийн зах зээлийн салбарын захирал (2009-2012)
- АНУ-д төвтэй EMPEA, Гүйцэтгэх захирал, (2013-2017)
- Хонг Бао Медиа Холдингс ХХК "Hong Bao Media Holdings Pte Ltd", ТУЗ-ийн гишүүн, Санхүүгийн хорооны дарга (2016-одоог хүртэл)
- АНУ-д төвтэй Serendra group, Гүйцэтгэх захирал, (2017-одоог хүртэл)
- Сий Ойл Филиппин корпорат, ТУЗ-ийн гишүүн, Засаглалын хорооны дарга (2022-одоог хүртэл)
- Голомт банк, ТУЗ-ийн хараат бус гишүүн (2023-одоог хүртэл)

ХАНС ХОЛЗХАКЕР – (Голомт банкны ТУЗ-д шинээр анх удаа нэр дэвшиж буй нэр дэвшигч)

Боловсрол:

- Венийн Их сургууль, Нийгмийн ухааны сургууль, Социологийн докторант (1972-1984)
- Венийн Их сургууль, Эдийн засгийн сургууль, Эдийн засгийн шинжлэх ухааны магистр (1984-1988)

Ажлын туршлага:

- Венийн Техникийн Их сургууль, Судалгааны ажилтан, үйлдвэрийн зохион байгуулалтын төсөл, Эрдэм шинжилгээний ажилтан (1980-1984)
- Номура судалгааны хүрээлэн, Төв Европын эдийн засагч (1989-1993)



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Огноо: Даваа гараг, 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр

Хаана: Шангри-Ла зочид буудлын хүлээн авалтын их танхим

- General electric, Санхүүч (1998-2002)
- ГироКредит Судалгаа /GiroCredit Research/, Австрийн хөрөнгө оруулалтын банк, "Улс орны эрсдэл/судалгаа" хариуцсан захирал (1993-1999)
- Олон улсын санхүүгийн хүрээлэн, Чех, Словак, Словени, Украиныг хариуцсан ахлах эдийн засагч (1999-2001)
- ЮниКредит группын Банк Австри Кредитанштальт, ТЗЕ-ын орнуудын үнэлгээг хариуцсан ахлах эдийн засагч (2001-2008)
- ЮниКредит группын ATF Банк, Ерөнхий эдийн засагч (2008-2013)
- Naqhoz их сургууль / Т.Рыскуловын нэрэмжит Шинэ эдийн засгийн их сургууль, Шинжлэх ухааны ахлах зөвлөх (2014-2016)
- Голомт банк, Ерөнхий эдийн засагч (2016-2017)
- Европын сэргээн босголт, хөгжлийн банк, Төв Азийн тэргүүн эдийн засагч, дэд захирал (2017-2019)
- Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээлэн (CAREC Institute), Ерөнхий эдийн засагч (2020-одоог хүртэл)

Хурлын дарга Г.Ганболд: ТУЗ-ийн гишүүдийг сонгохдоо кумулятив аргаар сонгоно. Та бүхэнд тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Тогтоолын төсөл

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.4 дэх хэсэг, Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 04 сарын 15-ны өдрийн ээлжит хурлын санал хураалтыг тус тус үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ** нь:

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдээс хамгийн олон санал авсан дор дурдсан нэр дэвшигчдийг "Голомт банк" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр 2027 оны ээлжит Хувьцаа эзэмшигчдийн хурал хүртэл гурван жилийн хугацаатай сонгосугай.

Хурлын дарга Г.Ганболд: Та бүхэнд асуулт байхгүй бол одоо Ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх тухай ТУЗ-ийн гишүүн Д.Мөнхтөр танилцуулна.

Хэлэлцэх асуудал 7. Ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх тухай

Танилцуулсан нь:

ТУЗ-ийн гишүүн Д.Мөнхтөр:

- Ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр нь АНУ-д анх 1974 онд үүсэж байсан. Олон улсад 6533 гаруй байгууллага АХЭХ-ийг хэрэгжүүлдэг. Нийт 2.1 их наяд ам.долларын хөрөнгө цугларсан бөгөөд олон улсын засаглалын зарчимд хэрэгжүүлэхийг зөвлөсөн хөтөлбөр юм. Олон улсын томоохон банкууд хэрэгжүүлдэгээс "Кредит Свисс", "Жэй Пи Морган" зэрэг банкууд байна. Олон улсад батлагдсан амжилтын түүхээс сайн талуудыг дурдвал ажилчдын ашигт ажиллагаа нэмэгдэж, хувьцааны үнэ ханшид сайнаар нөлөөлөн сайн ажиллах хүчин урт хугацаанд ажилладаг байна.
- Голомт банк нь анх 2011 онд Ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд тухайн үед хязгаарлагдмал хариуцлагатай компани байсан учраас өөрийн нөхцөл байдалд тохируулж энэ хөтөлбөрийг хэрэгжүүлж байсан. Нийт 576 ажилтан АХЭХ-д хамрагдсанв 2022 онд Голомт банк хувьцаат компани болсноор ажилтнуудын бүх хувьцаа Хөрөнгийн бирж дээр нээлттэй



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Огноо: Даваа гараг, 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр

Хаана: Шангри-Ла зочид буудлын хүлээн авалтын их танхим

арилжаалагдах болсон. АХЭХ-ийг хэрэгжүүлж эхлэхэд ажилтнууд холбоо маягийн зохион байгуулалтад орж ажилладаг байсан. 2022 оноос ХК болсноос хойш холбоо маягаар ажиллахаа больж ажилтнуудын тухайн үед эзэмшиж байсан хувьцаа нь МХБ-д нээлттэй байдлаар арилжаалагдах болсон байгаа.

- ТУЗ ярилцаад АХЭХ-ийг ХК болсонтой холбоотойгоор илүү сонгодог байдлаар цаашид хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзсэн. Энэхүү ХЭХ-д дараах шийдвэр гаргах саналыг дэвшүүлж байна. АХЭХ-ийг хэрэгжүүлэхийг ТУЗ-д зөвшөөрөх, хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой дүрэм журмыг батлахыг ХЭХ-ээс хүсэж байна. Дүрэм, журам, хэрхэн яаж, ямар нөхцөлтэйгөөр хэрэгжүүлэх талаар тодорхой болсны дараа ХЭХ-д хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах талаар эргэж хандах болно. Үүнтэй холбоотойгоор Голомт банкны дүрэмд өөрчлөлт орохоор байгаа. АХЭХ нь ач холбогдолтой хөтөлбөр учраас хувьцаа эзэмшигчид та бүгдийг энэхүү хөтөлбөрийг Голомт банканд хэрэгжүүлэхийг зөвшөөрч, шийдвэр гаргаж өгнө үү гэж хүсэж байна. Баярлалаа.

Хурлын дарга Г.Ганболд: Мөнхтөр гишүүнд баярлалаа. Та бүхэнд сая танилцуулсанчлан Голомт банк нь 2010 оноос эхлэн ХХК байхдаа дотооддоо тухайн үед хүчин төгөлдөр байсан хууль тогтоомжид нийцүүлэн АХЭХ-ийг маш амжилттай хэрэгжүүлсэн. 55 хүн нь сая IPO зарлагдахад хувьцаагаа шилжүүлэн орсон, бусад нь хувьцаагаа арилжаалсан. АХЭХ-ийн 2 гол ач холбогдол бол нэгдүгээрт, хувьцааны үр ашгийг нэмэгдүүлэхэд оршдог ба хоёрдугаарт, банкны ажилтнуудын тогтворжилт, суурьшлыг хангахад маш үр дүнтэй хэрэгсэл байдаг.

Одоо банк нээлттэй компани болсноор хөтөлбөрийг сонгодог утгаар нь хэрэгжүүлэх боломжтой болсон. Тийм учраас өнөөдрийн ХЭХ-ээр бид ТУЗ-д тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлж болно гэсэн зөвшөөрлийг олгох юм. Шийдвэрийг уншиж танилцуулъя.

Тогтоолын төсөл

“Ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр” хэрэгжүүлэх тухай

Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.8, 62 дугаар зүйлийн 62.1.8, 62.1.15 дахь заалт, Голомт банкны дүрмийн 8.2.12 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 04 сарын 15-ны өдрийн ээлжит хурлын санал хураалтыг тус тус үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

1. “Голомт банк” ХК-ийн зарласан хувьцааны хүрээнд Голомт банкны ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэхийг зөвшөөрсүгэй.
2. Ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбоотойгоор нэмж гаргах энгийн хувьцаанаас хувьцаа эзэмшигчдийн тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй.
3. Ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх, ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх нөхцөл, хэмжээ, хувьцаа эзэмшүүлэхтэй холбоотой журмыг батлах, энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

Асуулт, хариулт:

Хувьцаа эзэмшигч Алтанхуяг: ТУЗ-ийн хараат бус гишүүнд, жижиг хувьцаа эзэмшигчдээс монгол хүн дэвшүүлэх саналтай байна. Мөн АХЭХ-ийг хэрэгжүүлэхдээ нэмж хувьцаа гаргахгүй, нээлттэй арилжаалагдаж байгаа хувьцаанаас худалдан авах гэсэн саналтай байна.

ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга З.Солонго: ТУЗ-д нэр дэвшигчдийг бид ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэсэн. ТУЗ-ийн хараат бус гишүүнийн сонгон шалгаруулалтын зарыг 2024 оны 2-3 сард олон нийтэд зарлаж, нэр дэвшигчдийн анкетуудыг хүлээн авсан байгаа. Банкны тухай хууль болон Монголбанкны журмын дагуу банкны ТУЗ-ийн хараат бус гишүүн нь банк, санхүүгийн байгууллагад 10-аас дээш жил ажилласан, банк, санхүү, хуулийн мэргэжилтэй байх, түүнээс 5-аас доогүй



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Огноо: Даваа гараг, 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр

Хаана: Шангри-Ла зочид буудлын хүлээн авалтын их танхим

жил эрх бүхий албан тушаалтнаар ажилласан байх зэрэг өндөр шалгуурууд тавигдсан байдаг. Нээлттэй ТУЗ-ийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулахад нийт 6 анкет ирсэн ба нэр дэвшүүлэх хороо дээрх шаардлагыг хангасан нэр дэвшигчийг сонгон ХЭХ-д нэр дэвшүүлэх шийдвэр гаргасан.

Харин ажилчдад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийн хүрээнд хэрхэн хэрэгжүүлэх гэдэг журам нь тодорхойгүй байгаа учраас одоохондоо тодорхой хариулт хэлэх боломжгүй байна.

Хувьцаа эзэмшигч Алтанхуяг: Жижиг хувьцаа эзэмшигчдийн төлөөллийг ТУЗ-д оруулах сапалтай байна. Ажилчдад хувьцаа эзэмшүүлэх гэж байгаа юм бол ТУЗ нь журам, хөтөлбөрөө эхлээд боловсруулахгүй яасан юм бэ? ТУЗ-ийн гишүүд нь өөрсдөө хариулмаар байна.

Д.Мөнхтөр: Ажилчдын хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийг шинээр хэрэгжүүлэх үүднээс ТУЗ нь эхний ээлжинд хэрэгжүүлэх зөвшөөрлийг ХЭХ-аас авч байгаа ба үүний үндсэн дээр судалгаа хийж журмаа батлах зөвшөөрөл энэхүү хурлаас авч байна. Харин түүний дараа ямар хувьцааг хэрхэн хуваарилах гэдэг асуудлыг эргэж ХЭХ-д танилцуулан хөтөлбөрийг хэрэгжүүлэх юм.

Г.Ганболд: Таны саналыг бид хүлээн авлаа. Энэ удаагийн шийдвэрээр зөвхөн АХЭХ хөтөлбөр, журам боловсруулах, холбоотой судалгаа хийх эрхийг ТУЗ-д олгоно. Харин хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дахин Хувьцаа эзэмшигчдийн хурлаас шийдвэр авах болно.

Хувьцаа эзэмшигч Алтантуул: Манай аав олон жил Голомт банкаар үйлчлүүлж байна, бид хувьцаа авсан боловч манай Аавыг хуралд оруулсангүй. Мөн би банкны захирлуудад хувьцаатай холбоотой гомдол хүргэсэн ч хариу ирүүлээгүй. Мөн хувьцааны үнэ ханш уначихсан, тарааж буй ногдол ашиг нь хадгаламжийн хүүтэй харицуулахад хангалтгүй, бид алдагдалд орсон байгаа тул үүнд гомдолтой байна.

Г.Ганболд: Ойлголоо, Тооллогын комиссийн дарга хувьцаа эзэмшигчийн бүртгэлийн асуудлыг шийдвэрлэж өгнө үү. ТУЗ-ийн ажлын алба ирүүлсэн хүсэлт, гомдлыг шийдвэрлэж хариу өгнө. Харин хувьцааны үнэлгээтэй холбоотой Голомт капитал ҮЦК ХХК-ийн Гүйцэтгэх захирал С.Ган-Эрдэнэ бидэнд мэдээлэл хүргэнэ үү.

Голомт капитал ҮЦК ХХК-ийн Гүйцэтгэх захирал С.Ган-Эрдэнэ: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Миний бие Ган-Эрдэнэ Голомт капитал ҮЦК-ийн Гүйцэтгэх захирал байна. Голомт банкны хувьцааны ханш нь бирж дээр олон нийт хоорондоо арилжаалж байгаа арилжааны үндсэн дээр тогтож байгаа үнэ ханш юм. Өнгөрсөн 4 дэх өдөр Голомт банк нь 2024 оны 1 дүгээр улирлын санхүүгийн тайлангаа нийтэлсэн. Энэхүү тайланд эцсийн байдлаар Голомт банкны өөрийн хөрөнгө 1 их наяд тогрог, бирж дээр арилжаалагдаж буй 700 тэрбум төгрөг байна. Банкны одоогийн бирж дээр байгаа буусан үнэлгээ нь өөрийн хөрөнгийн үнэлгээний 67 хувь байна. Энэ нь ОУ-ын зах зээлийн ойлголтоор бодит үнэ цэнээсээ харьцангуй хямд байна гэж ойлгож болно. Дараагийн зүйл бол ашигт ажиллагаа юм. Таны хөрөнгө оруулсан банкны олж байгаа ашиг нь хэд вэ гэдэг нь чухал. 2024 оны 1 дүгээр улирлын ашгийг 2 банк зарлаад байна. Тэр бол Хас банк, Голомт банк 2 юм. Хас банкны зах зээлийн үнэлгээг дөнгөж сая шалгахад 720 тэрбум, Голомт банк мөн адил. Гэхдээ Голомт банкны ашиг бусад банктai харьцуулахад 86 тэрбум буюу 2 дахин их. Хувьцааны үнэ урт хугацаандаа байх ёстой түвшиндээ зайлшгүй очно. Богино хугацаанд тодорхой нөлөөллүүд бий. Нөгөө талаас банкны ашиг нь өмнөх жилийн 1 дүгээр улиралтай харьцуулахад 2.6 дахин өссөн. Ашигт ажиллагааны үнэ цэнэ маш өндөр байгаа. Манай ҮЦК-ий зүгээс Голомт банкны хувьцааг хадгалах, нэмж худалдан авах саналыг зөвлөж байгаа.

Хувьцаа эзэмшигч Довдондорж: Онлайнаар санал хураалтад орж байгаа хүмүүсийн санал, саналын тоог хармаар байна. ТУЗ-ийн бүрэлдэхүүнд хувьцаа эзэмшигчдээс оруулмаар байна, ТУЗ-ийн гишүүдийн тоог нэмэгдүүлээд ч юмуу. Дараа дараагийн удаад энэ тал дээр анхаарна уу.

Хурлын дарга Г.Ганболд: Ойлголоо таны саналыг хүлээн авлаа. За ингээд өөр асуулт байхгүй бол бид саналаа өгөх нэмэлт цаг 15-20 минут хувьцаа эзэмшигчдээ олгож байна. Түүний дараа Тооллогын комисс дүнг нэгтгэн танилцуулах болно. Ингээд түр завсарлая.

(20 минутын дараа) Бид одоо нийт санал хурааж дуусаад дүнг нэгтгэж байна. Дүнг нэгтгэсний дараа саналын үр дүнг нэгдсэн байдлаар танилцуулах болно.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Огноо: Даваа гараг, 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр

Хаана: Шангри-Ла зочид буудлын хүлээн авалтын их танхим

Тооллогын комиссын үр дүн:

Хурлын дарга Г.Ганболд: Санал тоолох процесс дууссан байна. Санал хураалтын дүнг Б.Ганбат захирал танилцуулна уу.

Тооллогын комиссын дарга Б.Ганбат: Тооллогын комиссын тогтоолыг танилцуулъя. Өглөө 09:00 цагийн байдлаар ирц авахад 88.48 хувийн ирцтэй байсан бол өнгөрсөн цаг хугацаанд нэмэгдээд одоогийн байдлаар 90.83 хувь болж ирц нэмэгдсэн. Нийт 715,514,208 ширхэг хувьцааг эзэмшиж буй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид саналаа өгсөн байна. Компанийн тухай хуулийн 67-р зүйлийн 67.3.8 хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 4 сарын 26-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн тогтоох нь. Ердийн аргаар нийт 3 санал хураалт явуулсан.

1. “Компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах”

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
730,559,744	99.579%	0	0.000%	3,086,689	0.421%

2. “Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны төсвийг батлах”

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
730,390,798	99.556%	157,143	0.021%	3,098,492	0.422%

3. “Ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх тухай”

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
729,867,083	99.49%	522,047	0.7%	3,257,303	0.44%

4. “ГУЗ-ийн гишүүдийг сонгох тухай”

Ердийн гишүүд:

Ч.Мөнхцэцэг – 736,746,610

Д.Мөнхтөр – 728,974,754

Ж.Үнэнбат – 728,155,366

О.Ганжолоо – 726,908,860

Урс Э.Шварценбах – 726,732,585

Хараат бус гишүүд:

Александр Пикер – 744,208,109

Жэймс Б.Двайер – 726,834,457

Ханс Холзхакер – 726,648,118

Роберт Ван Звитен – 726,631,384

Тус тус саналыг авч Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд сонгогдов.

Түдгэлзсэн саналын тоо: 30,977,654



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Огноо: Даваа гараг, 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр

Хаана: Шангри-Ла зочид буудлын хүлээн авалтын их танхим

Хурлын дарга Г.Ганболд: Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх 7 асуудлыг амжилттай хэлэлцэж, 4 шийдвэрээ 99.4 хувиас дээш саналтайгаар баталж баталгаажууллаа. Онлайнаар хуралд оролцож байгаа болоод өнөөдөр цаг зав гарган хүрэлцэн ирсэн эрхэм хүндэт хувьцаа эзэмшигч та бүхэнд банкны удирдлагын нэрийн өмнөөс талархал илэрхийлье. Голомт банкны бизнесийн гол концепци бол нээлттэй банк. Бид үйл ажиллагааны хувьд, засаглалын хувьд, санхүүгийн хувьд, мөн технологийн хувьд ч нээлттэй зарчмыг барьж, аль болох хамгийн хүртээмжтэй санхүүгийн үйлчилгээ үзүүлэхээр зорьж байна. Ийнхүү Голомт банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хаасныг мэдэгдье. Та бүхний эрхэлж байгаа ажил үйлст өндөр амжилт хүсэж, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсье. Дараагийн хувьцаа эзэмшигчдийн хурал хүртэл баяртай. Баярлалаа.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэхээр төлөвлөсөн 7 асуудлаас бүгд долоон асуудлыг хэлэлцэж хурлыг 12:30 минутад хаав.

ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦАЖ БАТАЛСАН:

ХУРЛЫН ДАРГА

ГАЛСАНГИЙН ГАНБОЛД

ТЭМДЭГЛЭЛ ХЯНАЖ БЭЛТГЭСЭН:

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

ЗАЛАА-УУЛЫН СОЛОНГО